



ГХБХБ

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3118,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn


2023.07.31 № 08/815
танай _____-ны № _____-г

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд 2023 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, биелэлтийг 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  М.АНХБАЯР



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ**

2023 оны 06 сарын 16 өдөр

Чойр хот

№	Үзүүлэлт	Үнэлгээ			
		Хувь	Жин	оноо	
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.	88.0	0.5	37.95
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	72.9		
		3.Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.	73.1		
		4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	73.1		
		5.Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө.	76.3		
		6.Шинэ сэргэлтийн бодлого.	72.0		
		Дундаж	75.9		
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.	89.7	0.15	13.29
		2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	88.0		
		3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.	90.0		
		4. Аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагч нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт.	86.7		
		Дундаж	88.6		
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.	86.9	0.2	17.99
		2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ.	100.0		
		3.Шударга байдлын түвшин -Авилгын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт -Тушаал, шийдвэр.	83.0		
		4.Хэрэглэгчийн үнэлгээ	-		
		Дундаж	89.97		
4	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт. -Ногоон байгууламж (Мод тарих) -Цахим шилжилт -Хог хаягдлын менежмент	90.6	0.15	12.75
		2.Нээлттэй Говьсүмбэр	68.1		
		Дундаж	85.0		
		Ерөнхий үнэлгээ			

ДҮГНЭЛТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг **81.98 хувь буюу "В"** үнэллээ.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаар хурлын шийдвэрээр даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг **88.0 хувь**, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг **86.7 хувь** гэсэн үнэлгээг хэлэлцээд баталгаажуулав.

ЗӨВЛӨМЖ

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжоос өөрийн байгууллагад хамааралтай заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, бодит үр дүнг дээшлүүлэх;
- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа зорилт арга хэмжээнд нийцсэн, шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшин хүрсэн эсэхийг илэрхийлж тайлагнах;
- Үнэлгээг Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын 6.2.1, 6.2.2-д заасан аргачлалын дагуу үнэлэх, 2000 тэмдэгтэд багтаан товч, тодорхой тайлагнах;
- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнах.

Дараах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр идэвх, санаачлага гарган, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах. Үүнд:

- Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлэх;
- УАБЗ-ийн 2010 оны " газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай" 10/09 дүгээр зөвлөмжийн 1-д "Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх"
- Шивээговь суманд Соёлын төв, Баян тал суманд Соёлын спортын цогцолборыг барих.
- Усан бассейн бүхий цогцолборыг барих.
- "Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.
- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах.
- Боржигин өв музей, Нийтийн номын сангийн байрыг засварлах.
- Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын зураг төсвийг хийлгэж, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэх.
- Аймгийн төвд авто үйлчилгээний төв байгуулах.

- Чойр хотын ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлыг эрчимжүүлж, удирдан зохион байгуулах.
- Сүмбэр сумын дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
- Сумдын инженерийн дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх чиглэлээр бодлогын хэрэгжилтийг хангуулах, хамтран ажиллах.
- Ус, дулаанаар хангагч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллах.
- Ерөнхийлөгчийн 2018 оны "Монгол бичгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 46 дугаар зарлигийн 3-т "Албан байгууллага, аж ахуй нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллах.
- Аймаг, сумдын төвд үерийн далан байгуулах, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүнг дээшлүүлэх.
- Шинэ сэргэлтийн бодлого, "Нээлттэй Говьсүмбэр" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, сурталчлах

2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- Гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч, бодлогын зорилт, гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, үр дүнг тоон болон чанарын түвшинд тооцож тайлагнах.
- 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.2, 1.2.1 дахь арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.
- Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь биелүүлж, үр дүнг тайлагнах;
- Нэг өрх-Нэг ажлын байр" арга хэмжээний үр дүнтэй зохион байгуулах, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулж угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж, үр дүнг тайлагнаж ажиллах.

3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

Байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэн, цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулах;

- Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх. Ёс зүйн зөвлөлийг журмын дагуу ажиллуулж, үйл ажиллаа, үр дүнг цахим хуудсанд мэдээлэх;
- Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах;
- Хуулийн хүрээнд төрийн албаны сул орон тоог зарлан, нөхөж, зөрчилтэй томилгоог арилгах, холбогдох мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулах;
- Төрийн албан хаагчдыг томилсон, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан тухай дүгнэлт болон төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гаргасан шийдвэрүүдийг цахим хуудсанд ил тод байршуулах;
- Төрийн байгууллагын хүний нөөцийн нэгдсэн системийн үйл ажиллагааг хангаж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэн, тухай бүр өөрчлөлт, баяжилтыг хийх, байгууллагын албан хаагчдын танилцуулга, мэдээллийг цахим хуудсанд байршуулах;
- Байгууллагын бүтэц, орон тоог хууль, тогтоомжийн хүрээнд тогтоож, бүтэц орон тооны дагуу албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох мэдээ, мэдээллийг ил тод байршуулах;
- Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд батлан мөрдүүлэх. Дотоод журмын хэрэгжилтийг ил тод мэдээлэх.

Шилэн дансны хөтлөлтийг сайжруулах чиглэлээр:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах.

Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг дээшлүүлэх чиглэлээр:

- Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу нотломжтой тайлагнах.
- Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг сүүлийн хагас жилд эрчимжүүлж бодитой, үр дүнтэй ажил зохион байгуулах.
- Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг контент, шторкыг сурталчилах.
- Тушаалын хууль, эрх зүйн үндэслэл хэсэгт албан тоот авахгүй байх.

4. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:

Ногоон байгууламжийн чиглэлээр:

- Хариуцсан талбайн мод сөөгийн ургалт амьдралтын хувийг бууруулахгүй байх
- Мод ногоон байгууламж, арчилгаа усалгааны талаар сургалт нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх.
- Мод тарих, тарьц суулгац бэлтгэх, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжид газар олгох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах.

Цахимжуулалтын чиглэлээр:

- Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахимжуулж, e-mongolia систем болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээний e-mongolia системийг сурталчлах

- Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг дээшлүүлэх.
- Тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ болон байгууллагын дотоод удирдлагын цахим системийн үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах.
- Үндэсний дата төвөөс олгосон домайн хаягийг ашиглах, албан хаагчдад албан ёсны төрийн цахим хаяг нээж, төрийн цахим шууданг нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулах
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон бусад шаардлагатай төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэх.
- Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд мэдээ, мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэхэд анхаарах.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд холбогдох мэдээллийг цахим хуудсаар иргэдэд хүргэж ажиллах.
- Цахим үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн аппликэйшн, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх.

Хог хаягдлын менежментийн чиглэлээр:

- Байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах, үйл ажиллагааг сурталчлах, сургалт нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх;
- Хог хаягдлаа бүртгэлжүүлэн, дахивар авах хоршоотой хамтарч ажиллах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ НЭГТГЭСЭН:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн



М. Анхбаяр

Б. Мөнхзаяа